



БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ  
ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Г. ГАНДӨЛ ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.03.11 № 586  
таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад заасны дагуу Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨААТҮГ-ЫН 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨААТҮГ-ЫН 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бodoх бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хулээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨААТҮГ-ЫН 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨААТҮГ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮРӨРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.МОНХ-ОЧИР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020. 03. 11 № 585  
таний \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН  
НЭГЖ ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
Г. ГАНДӨЛ ТАНАА

"Бэлчээрийн менежмент төслийн нэгж"  
ОНӨААТҮГ-ЫН 2019 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 26 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮРӨРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МОНХ-ОЧИР

002030329

D:\Documents\Documents\2020 onyuwulan bichig\2020.03.09 Belcheeliin-MTU AS.docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020. 03. 11 № 584

танай -ны № -т

Г БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН  
НЭГЖ ОНӨТҮГ-ЫН ДАРГА  
Г.ГАЛДӨЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийллээ.

Аудитаар илэрсэн 400.0 мянган төгрөгийн зэрчилд тогтоосон төлбөрийн актыг хүргүүлж байна.

Төлбөрийн актыг заасан хугацаанд барагдуулж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ   
 Б.МОНХ-ОЧИР

D:\Documents\Documents\2020 onyuwulsan bichig\2020.03.11.Belcheerlin.management.akt.A5.docx

002030346



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 01/45  
НТАГ - 2020/8/01 - 0100001

Улаанбаатар хот

### ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Салбарын тэргүүний ажилтнаар шагнагдсан 3 төрийн албан хаагчдад 400,000.00 /дөрвөн зуун мянга/ төгрөгийн шагнал олгосон нь; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1 “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно”, 3.1.7. “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан.” заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

- Зөрчлийн нийт 400,000.00 /дөрвөн зуун мянга/ төгрөгийг Нийслэлийн төрийн сан дахь НТАГ. хүү тorgуул 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар, Дундманхайдай аудит ХХК-д ирүүлэхийг Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын дарга Г.Галдөл, нягтлан бодогч Ц.Мөнхдөл нарт хариуцуулав.<sup>1</sup>

<sup>1</sup> Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас таёвсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг Төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.” гэж заасны дагуу албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

**АКТ**

**ТОГТООСОН:**

“ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ” ХХК-ИЙН

**АУДИТОР:**



**ЗӨВШӨӨРСӨН:**

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ  
ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ-ЫН  
ДАРГА




**ХЯНАСАН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН  
АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.БАТ-ӨЛЗИЙ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2020/8/СТА-ОНӨААН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2020 он

Тэргүүлэх аудитор:	Ж.Бямбажав
Утас: 99085151	Цахим хаяг:byambaahunnu@yahoo.com
Аудитын менежер:	Г.Цэдэнбалжир
Утас: 91991462	Цахим хаяг: dum_audit@yahoo.com
Аудитор:	Н.Тэмүүжин
Утас:88103399	Цахим хаяг: dum_audit@yahoo.com

### Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчйт төсөвт үйлдвэрийн газар

## **Агуулга**

<b>Агуулга .....</b>	<b>2</b>
<b>1.Аудитын гэрчилгээ .....</b>	<b>3</b>
<b>2.Аудитын тайлан.....</b>	<b>5</b>
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Няглан бodoх бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал..	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
<b>3.МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ .....</b>	<b>11</b>
<b>4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....</b>	<b>15</b>
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	15
4.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	16
4.3.Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.4Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	21

## Аудитын гэрчилгээ



БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ  
ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Г. ГАНДӨЛ ТАНАА

### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-майл: ib@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.03.11 № 586  
таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 14.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад заасны дагуу Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бodoх бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дун хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглувансан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨААТҮГ нь Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТУРОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.МӨНХ-ОЧИР

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын дарга Г.Гандөл танд танилцуулж байна.

Энэхүү тайландаа үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд НТАГ-тай байгуулсан гуравласан гэрээг үндэслэн аудит хийлээ.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 20-ноос 2020 оны 03 дугаар сарын 04-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Дундманхайдай Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дундманхайдай Аудит ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 11 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалыар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго: "Нийслэл хот орчмын бэлчээрийг сайжруулах, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд Бүгд Найрамдах Австри Улсын техник, технологийг нутагшуулах замаар нийслэл орчмын байгалийн бэлчээрийг сайжруулан, тэжээлийн олон наст ургамлын холимгийг тарьж, чанар сайтай хадлан, тэжээл авч, нэг үнээнээс саалийн хугацаанд авах сүүний гарцыг нэмэгдүүлэн, нийслэлийн иргэдийн сүүний хангамжийг дээшлүүлэхэд оршино.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах шинэ технологийг нэвтрүүлснээр бэлчээрийн талхагдлыг багасгаж, цөлжилтийг бууруулна.
2. Тэжээлийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг 2-3 дахин ихэсгэх боломж бүрдэнэ /odoogийн байдлаар 1 га -гаас 500 орчим кг хадлан авдаг/.
3. Дээрх шинэ технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр өвөл, хаврын улиралд ч шимт чанарыг алдагдуулахгүйгээр малаа тэжээх боломж бурдэнэ.
4. Туршилтын талбай, тэжээл, сүүний гарцын судалгаа болон сургалт, засварын төв бүхий "Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй" байгуулна.
5. Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах ба ингэснээр төслийн хүрээнд хийх "Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй"-нд тулгуурлан практик байдлаар дээрх дэвшилтэт технологиудыг танилцуулах, сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, хамтран ажиллах, бодитоор хэрэгжүүлэхэд нь туслах юм.
6. Нэг монгол үнээнээс саалийн хугацаанд авах сүүний гарц 2000 л байдаг бол нэгж талбайгаас авах ногоон массын ургац болон тэжээлийн шимт чанарыг сайжруулснаар сүүний гарцыг 2 дахин нэмэгдүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материалыг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж зурсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт хууль тогтоомжтой нийцсэн боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан нэмэлт сайжруулалт хийх шаардлагатай.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 34 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 376,740.0 мянган төгрөгөөс тооцон 3,767.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 4,453.7 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлын дүн 445,368.4 мянган төгрөг буюу 18.2 хувиар өссөнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 131.1 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,103.4	0	-2,103.4
Бараа материал	125,271.1	125,163.1	-108.0

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11.7	0	-11.7
Үндсэн хөрөнгө	1,141,259.8	1,012,347.5	-128,912.3
Биет бус хөрөнгө	4,633.3	5,128.7	495.4
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,268,646.0</b>	<b>1,137,510.6</b>	<b>-131,135.4</b>
Өглөг	27.1	0.0	-27.1
Засгийн газрын хувь оролцоо	1,268,618.9	1,137,510.6	-131,108.3
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>1,268,646.0</b>	<b>1,137,510.6</b>	<b>-131,135.4</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь 2017-2018 онд үүссэн авлагаа барагдуулснаас шалтгаалсан. 2017 онд үүссэн ажил үйлчилгээний 2,088.0 мянган төгрөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагын хүсэлтийг харгалзан үзэж байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэр, даргын тушаалын дагуу зах зээлийн ханшаар нь малын тэжээлээр дүйцүүлэн авлага хаахаар шийдвэрлэсний дагуу бараа материал хүлээлцэх, тооцоо нийлсэн актаар баталгаажуулан холбогдох дансанд бүртгэсэн. Албан хаагчдын цалин хөлсний ашгийн татварын зөрүү үүссэн 15.4 мянган төгрөгийг тайлант онд запруулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь байгууллагын даргын 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн А/26 тоот тушаалын дагуу бараа материал актalsнаас шалтгаалсан ба үнэ төлбөргүй хүлээн авсан 94.2 мянган төгрөгийн бараа материалыг орлого авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь элэгдлийн зардал нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Биет бус хөрөнгө өссөн нь нярвын программ 275.0 мянган төгрөг, Веб сайтын хөгжүүлэлт хийлгэсэн 500.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 27.1 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь ажилчидтай холбогдон гарсан ашгийн зөрүү барагдуулсан байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнаад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 18,428.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 18,428.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

### Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Техник үйлчилгээний орлого	349.5	349.5	-	100
Сүүний орлого	7,379.2	7,379.2	-	100
Хүнсний ногоо	175.0	175.0	-	100
Мал борлуулсан орлого	10,185.0	10,185.0	-	100
Үрийн орлого	340.0	340.0	-	100
<b>Нийт дүн</b>	<b>18,428.7</b>	<b>18,428.7</b>		

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 295,739.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, нийт зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 283,533.1 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь гэрэл цахилгаан, тээвэр шатахууны зардалд тус тус хэмнэлт гаргаж батлагдсан төсвөөс 12,205.9 мянган төгрөгийг дутуу зарцуулжээ.

Үндсэн үйл ажиллагаанаас 18,428.7 мянган төгрөгийн орлого, 12,205.9 мянган төгрөгийн зардлын хэмнэлт нийт 30,634.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 36 эрсдэл тодорхойлж нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3,285.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 400.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,885.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 3,285.4 мянган төгрөгийн запруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 400.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ. Үүнд:

Байгууллага салбарын тэргүүний ажилтнаар шагнагдсан 3 төрийн албан хаагчдад 400.0 мянган төгрөгийн шагнал олгосон нь (Эрх ба үүрэг) батламж мэдэгдэлтэй нийцээгүй ба Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хөрөнгийн ангилал, ашиглалт, гэрээний үүргийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг дараагийн аудитад хамруулан горим, сорил хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч тайлант хугацааны байгуулсан элэгдлийн зардлаараа үлдэх өртөг “0” үлдэгдэлтэй болсон 2,237.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй 10 нэр төрлийн хөрөнгө буюу бараа материалын дансанд түрдэг тэрэг, 2 ш ном нийт 212.0 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгааг;

Харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний биелэлт, гэрээг дүгнэж акт үйлдэж, үр дүнг тооцсон эсэх.

Тус Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь үйл ажиллагааны чиглэл статус, бүтэц, зохион байгуулалтын хувьд цаашид тухайн оны зорилтод түвшнийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газраар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,248.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай.

## 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайландауд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсгийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сүл талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринеас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Зардлын данстай холбоотой асуудал

#### 3.1.1 Илрүүлэлт:

“Нутаг академи” НҮТББ-тай 771.4 мянган төгрөгийн гэрээт ажлын гүйцэтгэлийн акт, холбогдох санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлгүйгээр төлбөрийг шилжүүлсэн. Энэ нь (Үнэн зөв байх, Эрх ба үүрэг) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланда тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн.

#### 3.1.2 Эрсдэл:

Хөрөнгө шамшигдуулах, хөрөнгийн дутагдал үүсэх, холбогдох журам зөрчих.

#### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх, бүртгэлд тавих хяналтыг сайжруулах.

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 14 тоот албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар хариу ирүүлсэн.

